

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ

PROFESSIONAL ETIQUETTE

**Б.ӨЛЗИЙСАЙХАН**

ХУИС-ийн харьяа Билиг дээд сургуулийн Сургалтын албаны эрхлэгч,
ХСИС-ийн докторант

ULZIISAIKHAN B.

Director, Study Board at Bilig Institute, University of Humanities

Товч утга: Ёс зүй бол хууль биш, хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулах уламжлалт хэв шинжит хэрэглүүр юм. Ёс зүй нь өөрөө сайн сайхан зүйлийг хэвшүүлэх зорилго бүхий шинжлэх ухаан, энэ утгаар нь мэргэжлийн ёс зүйн тухайлсан шинж чанарыг ёс зүйн онолд уялдуулан судалж үзэв.

Энэхүү сэдвийн хүрээнд ёс зүйн үүсэл, түүний дотоод агуулга, уг чанар, философийн онолын бусад ойлголтоос ялгагдах хэв шинж, нийгмийн харилцаанд түүний эзлэх байр суурийг тодруулан, улмаар мэргэжлийн ёс зүйн зарчим ба хэм хэмжээний тухай өгүүллээ.

Abstract: Ethics is now law. It is the traditional way of governing human relationship. Ethics, itself, is a science for habituating well-being; therefore here we have studied professional etiquette character on the basis of ethics theory.

Within the range of this topic, here we tried to determine origin of ethics, its internal significance, marrow, and difference from other concepts of philosophical theory, social status in social communication as well as professional etiquette principle and norm.

Түлхүүр үгс:

1. Ёс зүй (хоршоо үг) - байвал зохих шаардлага, дэг.
2. Ёс суртахуун - дагавал зохих, хүнд байвал зохих зан суртал. Нийгмийн ухамсрын нэг хэлбэр нийгмийн амьдралын бүх салбарт хүний зан төлөвийг зохицуулагч нийгмийн үзэгдэл. Ёс суртахуун бол түүхэн үзэгдэл мөн.
3. Мэргэжлийн ёс зүй — тодорхой мэргэжлийн хүмүүсийн харилцааны хамгийн нарийн дэг жаяг.
4. Хуульчийн ёс зүй - мэргэжлийн үүргээ хэрэгжүүлэхэд түүний зан үйлд нийгмийн зүгээс тавьж буй ёс суртахууны тусгай шаардлага.

Key words:

1. Ethics-the study of what is morally right and what is not.
2. Morally — proper social behavior, morality is historical phenomenon
3. Professional etiquette- the code of ethical behavior among
4. Lawyer ethics- primarily apply to lawyer, while code of professional responsibility the code of ethical behavior among the members of a profession.

Нэг. Ёс зүй нь ёс суртахууны мөн чанар, үнэлэмжийг судалдаг практик философийн ухаан. Ёс суртахуун нь хүний дотоод итгэл үнэмшил юм.^[1] Ёс зүй гэдэг ойлголт нь хүний биеэ авч явах байдлын мөн чанар (философийн категори)-ыг судлах онол, ёс суртахуун нь нийгмийн ахуйг тусгасан ухамсрын хэлбэр юм. Аристотель. Дээд ёс суртахуун: Ёс зүй бол төр улсын ухааны бүрэлдэхүүн хэсэг юм.^[2] Ёс зүйн утга агуулгыг тодорхойлдог хэм хэмжээг “Ёс суртахуун” гэж, эрх зүйн шинжлэх ухааны утга агуулгыг тодорхойлдог хэм хэмжээг “Эрх зүй” гэж нэрлэдэг.^[3] Ёс суртахууны хэм хэмжээг бүтцийн хувьд диспозици, гипотез, санкци гэж 3 ангилж

¹ Золзаяа М. Ёс зүй. УБ, 2014. 8 дахь тал

² Даш-Ёндон Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж II боть, УБ., 2011. 20 дахь тал

³ Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол. ШУА-ийн ФСЭХ.УБ., 2013. 17 дахь тал

үздэг.^[4] Ёс суртахууны журамласан хандлага, санкци нь албадлагын шинжтэй байдаггүй ба үүргээрээ эрх зүйн санкцаас ялгаатай бөгөөд эрх зүйн санкци шиг зөвхөн хэм хэмжээ зөрчигдсөн тохиолдолд биш, харин хэм хэмжээнд тохирсон зан үйлд мөн адил хэрэглэгдэнэ. ...нийгмийн дэг журамд харш зан үйлд шийтгэл ногдуулах, биеэ буруу авч яваа этгээдийг залхаан цээрлүүлэх, эерэг тохиолдолд урамшуулах, хөхиүлэн дэмжих ёстой.^[5] Ёс суртахуун гэдэг нь нийгмийн дотор хүмүүсийн зан үйлдлийг хэм хэмжээгээр зохицуулах үндсэн аргын нэг, нийгмийн харилцааны онцгой төрөл мөн. Ёс суртахууны хэм хэмжээ нь тухайн нийгэм дэх хүмүүсийн зан байдлын тодорхой дүр загвар буюу хэвшиж тогтсон стандарт, хүмүүсийн зан байдлыг зохицуулагч шаардлагуудын цогцлол мөн.^[6] Ёс зүйн ухааныг олон улсын хэмжээнд “Этика” гэж нэрлэж заншсан. Этика гэдэг нь зан заншил гэсэн утгатай Грек үг. Капиталист нийгэмд “Хүн хүндээ чоно” гэдэг зарчимд үндэслэсэн хөрөнгөтний ёс суртахуун, “Нэг нь нийтийн төлөө, нийт нь нэгнийхээ төлөө” гэсэн социалист ёс суртахуун бие биеийн эсрэг зөрөн зогсож байсан нь ёс суртахуун бол ангийн чанартай хөгжиж ирснийг нотлосон төдийгүй, ёс суртахуун бол хүмүүсийн хоорондын өдөр тутмын харилцааны нэн чухал тохируулга ^[7] болж өгснийг гэрчилсэн хэрэг юм. Ёс зүй хэмээх ойлголт нь эртний Грекийн “ethos” гэдэг үгнээс гаралтай ба латины “mos” (moris)-тай утга дүйх бөгөөд энэ нь зан авир, дэг журам гэсэн утгатай. “Этика” (ёс зүй) хэмээх ойлголт нь эртний Римээс үүсэлтэй гэж үздэг. “Mos” гэсэн үгнээс “moralitas”(ёс суртахуун) хэмээх нэр томьёог бий болж Грекийн этика гэдэг үгнээс латин хэлний “мораль” гэдэг үг үүсч анх нэг утгатай байснаа хөгжлийн явцад “этика” нь ёс зүй, “мораль” нь ёс суртахуун гэсэн хоёр өөр утгатай ойлголт болсон.

Ийнхүү нийгмийн хөгжлийн явцад “этика”, “мораль” гэдэг нэр томьёо нь янз бүрийн утга агуулгаар баяжигдан, “этика” (ёс зүй) нь мэдлэгийн бие даасан салбар болж, “мораль” нь тухайн шинжлэх ухааны судлагдахуун болсон байна. Эндээс үзвэл ёс зүй бол ёс суртахууны тухай шинжлэх ухаан юм.^[7] Ёс зүй бол нийгмийн харилцааг бүхэлд нь хамран удирдах, зохицуулах, хэвшүүлэх зорилт бүхий нарийн мэргэжил эрхэлж байгаа хүмүүсийн ёс суртахуун (хүний зан төлвийн сайн, муу, сайхан, муухай эсрэг, сөрөг, шинжүүдийг үнэлэх нийтийн хэм хэмжээний нийлбэр цогц)-ыг судалдаг шинжлэх ухаан юм.^[8] Орчин үеийн ёс зүйн хувьд эрх чөлөө гэдэг нь хариуцлага юм. Ёс суртахууны хариуцлага нь нийгмийн бусад төрлийн хариуцлагын үндэс болдог бөгөөд бие хүний ёс суртахууны үйл ажиллагаа түүний үүрэгтэй тохирч байгаа байдал.^[9] Ёс зүй нь ёс суртахууны тухай мэдлэгийг буй болгоод зогсохгүй, ёс суртахууны сайн үйлс, хэм хэмжээ, эрхэм дээд туйлын хүслэнг буй болгоход оролцдог. Ёс суртахуун бол ёс зүйн судлах зүйл нь, өөрөөр хэлбэл танигдан мэдэгдэж буй объект нь ёс суртахуун, түүнийг танин мэдэж буй мэдлэг ухааны салбар нь ёс зүй мөн.^[10]

Өнөө үед ёс зүйг онолын ба норматив ёс зүй гэж ангилж байна.

а) Онолын ёс зүй - ёс суртахууны үүсэл, мөн чанарын асуудлууд нийгмийн

⁴ Батбаяр Ц. Ёс зүй. УБ., 2010. 7-30 дахь тал

⁵ Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол. ШУА-ийн ФСЭХ.УБ., 2013. 36-38 дахь тал

⁶ Сумъяа Б. Ёс зүйн үндэс. УБ., 2001. 34, 55 дахь тал

⁷ Чимид Б., Дашжамц Д. Эрх зүй ёс-суртахуун. УБ., 1987. 10-12 дахь тал

⁸ Тунгалаг Т. Ёс зүй. УБ., 2002. 7 дахь тал

⁹ Амарсанаа Ж., нар. Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003. 106 дах тал

¹⁰ Батбаяр Ц. Ёс зүй. УБ., 2007. 75-76 дахь тал

харилцааны системд түүний эзлэх байр суурийг тодруулах, зан суртахууны ухамсрын хэлбэр, бүтцийг тайлбарлах;

б) Норматив ёс зүй - хүмүүс ёс суртахууны зарчим ба хэм хэмжээг хэрхэн сахин биелүүлэх зэрэг асуудалд хариулт өгдөг.^[11]

Аристотель. Дээд ёс суртахуун: Ёс зүйн сайн үйл нь зан авир гэдэг "Ethos" заншил гэсэн үгнээс гарчээ, ийм учраас ёс зүйн сайн үйл гэсэн үг зуршил гэдэг үгтэй уялдан дуудагдаж нэрлэгдэж байгаа бөгөөд ёс зүйн сайн үйл нь дутагдах, илүүдэх нь аль аль нь хортой.^[12]

Эртний Грекийн софистууд янз бүрийн улс орны хэв хууль, ёс, ёс заншлыг судлаад хууль ёс заншлын гол агуулга нь ёс суртахуун гэж дүгнэж байжээ.

Академич С.Нарангэрэл: "1990 оноос хойш барууныг (ялангуяа америкийг) шүтэн биширч, хуулиар хориглоогүй бүхнийг үйлдэхийг зөвшөөрнө хэмээсэн баримтлалыг дагаснаас болж, ёс суртахууны уламжлалаа уландаа гишгэж, оюун санааны хий хоосон орон зай гаргахад хүргэжээ. Энэ хоосон орон зайд мөнгө, албан тушаалыг шүтэх үзэл хүчтэй болсноор оюун санааны үнэ цэнэтэй зүйлсийг үгүйсгэж, луйвар, залилан мэхлэлт газар авсан"^[13] гэж тэмдэглэжээ.

Ёс суртахуун нийгмийн бүхий л харилцаанд илэрч байдаг. Тухайлбал улс төрийн харилцаа нь хүмүүнлэг ба хүмүүнлэг бус, эдийн засгийн харилцаа нь шударга ба шударга бус, оюун санааны харилцаа нь үнэнч ба үнэнч бус ёс суртахууны мөн чанараар тодорхойлогддог.

Ёс суртахуун бол сайн, муу үйл, шударга бус, үүрэг, нэр төр, нинжин сэтгэлийн тухай хүмүүсийн төсөөллийг илэрхийлэгч зан байдлын дүрэм горим хэм хэмжээний цогц юм"^[14] гэж үзсэн байна. Эдгээрээс үзвэл, ёс суртахуун нь хэм хэмжээ, үнэлэмж, хүний дотоод сэтгэлийн чанар юм. Иймд ёс суртахууны асуудлыг олон талаас нь тунгаан эргэцүүлэх шаардлагатай.

Ёс суртахуун нийгмийн ухамсрын нэг өвөрмөц хэлбэр бөгөөд хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулагч, хүний биеэ авч явах хэм хэмжээний цогцос мөн. Ёс суртахуун нь хүмүүсийн хоорондын харилцааны амин чухал хэрэгцээнээс үүсэн гарч ангич, намч чанартай, бодит шалтгаан үндэслэлтэй, нийгмийн хөгжлийн хэр хэмжээтэй нөхцөлдөн шүтэлцэн хөгжиж иржээ.^[15]

Ёс зүйн гол зорилт нь зан заншил, биеэ авч явах байдлыг судлан шинжлэхэд бус ёс суртахууны гарал үүсэл, түүний зарчмуудыг тодорхойлоход оршино. Ёс суртахууны үйлдэл нь тодорхой зорилготой байхаас гадна түүний ёс суртахууны гол зарчмын дагуу хэрэглэнэ.

Хүний үйл ажиллагааг ёс горим, хэм хэмжээнд чиглүүлэх шаардлагыг ёс суртахууны зарчим гэдэг. Хүнлэг ёсыг дээдлэх, эх орон байгаль дэлхийгээ хайрлах, эв эеийг хичээх, өглөгч сэтгэлтэй байх, нэр төр, алдар хүндийг хайрлан хамгаалах, хичээнгүй хөдөлмөрч байх, хүнлэг энэрэнгүй байх, шударга, үнэнч ёсыг баримтлах зэрэг болно.

Аристотель. Евдемийн ёс зүй: Нотлох юм уу үгүйсгэх байдлаар үнэнийг

¹¹ Сумъяа Б. Ёс зүйн үндэс. УБ., 2001. 8-9 дэх тал

¹² Вандангомбо Р. Төрийн албаны ёс зүй. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2007. 15 дахь тал

¹³ Даш-Ёндон Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж II боть, УБ., 2011. 31 дэх тал

¹⁴ Нарангэрэл С. Ёс суртахуун - эрх зүйн судалгааны зарим үр дүн. Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл). УБ., 2014. 23 дахь тал.

¹⁵ Амаржаргал Т. Ёс суртахууны тухай өгүүлэх нь. УБ., 1991. 3 дахь тал

илэрхийлэх таван [арга зам] сэтгэл санаанд байдгийг иш үндэс болгоё, үүнд, урлаг, шинжлэх ухааны мэдлэг, ухаан зарах сэтгэлгээ, мэргэн ухаан, хийсвэрлэл.^[16] ...ухаан зарах сэтгэлгээ нь өрхийн аж ахуйн, хууль тогтоомж, улс төрийн (зөвлөлдөх ба шүүхийн) үйл ажиллагаа гэсэн хэсгүүдээс тогтоно.

Ёс суртахууны хэм хэмжээ, зарчим бол өдөр тутмын харилцаанд илэрдэг туршлага юм.^[17] Бид аливаа ёс суртахуунгүй үйлдэлд үнэлэлт өгч, бурууг засаж залруулах нь эргээд зөв сонголт, шийдвэр гаргахад нөлөөлдөг. Иммораль буюу ёс суртахуунгүй үйлдлээс сэргийлж сургамж авч байдгийг үгүйсгэх аргагүй. Ёс суртахуун нь хуульд захирагдах, тухайн нөхцөл байдалд тохирсон хэм хэмжээ, ёс суртахууны сургаалыг дагаж мөрдөх нь хүний төлөвшил хандлагыг илэрхийлдэг.

Ёс суртахууны тогтолцоо нь хэм хэмжээ, үнэлэмж, эрхэмлэл, зарчим гэсэн үнэлэмжүүдээс бүрдэнэ. Ёс суртахууны хэм хэмжээ нь шинжлэх ухаан, нийгэм, улс төр гээд амьдралын бүхий л хүрээнд үйлчилнэ. Хууль эрх зүйн зохицуулалт нь төрийн албадлага шаардлага бөгөөд тодорхой институтууд хянах үүрэгтэй байдаг. Ёс суртахууны зохицуулалт нь хувийн ухамсарт тулгуурладаг бол хуулийн хэм хэмжээ нь юуг хийж болохгүйг тодорхой утгаар заасан байдаг. Хууль бол нэг талаас ёс суртахууны хэм хэмжээг баталгаажуулсан хэлбэр юм. Эрхээ эдэлж байна гээд бусдын эрхэнд халдан, дур зоргоороо авирлаж болохгүйг ёс суртахууны хувьд ухамсарлах, хувь хүн зөвхөн өөрийн төлөө биш бусдын өмнө сонгосон зорилгын төлөө ухаалаг, зөв эрүүл саруул замыг эрэлхийлэх нь хүмүүнлэг нийгмийн үндэс юм. Гэвч ардчилсан чөлөөт нийгэмд эрхээ эдэлж байна гэсэн нэрийдлээр нийгэмд эмх замбараагүй байдлыг үүсгэн хуулийн нэрийг барьж албан тушаалаа хэтрүүлэн ашиглах, үүргээ үл ухамсарлан хүнд суртал гаргах, өөрсдийн амьдрах эрх үүргээ төрд даатган, бухимдлыг үүсгэж төрд гомдоллож байгаа зэрэгт бүгд л хувь хүний ухамсар, үүрэг хариуцлага, ёс суртахуунтай л холбоотой. Төрийн үүрэг бол буруу үйлдлээс иргэнийг хамгаалах, нийгэмд ашигтай үйлдлийг хэрэглээнд оруулах, иргэдийн хамтын үйл ажиллагааг шударгаар зохицуулах явдал юм.

Хувь хүний ёс суртахууны үүднээс ямар харилцаанд оршиж буйгаа ухамсарлаж, харилцан эрх, үүрэг хүлээсэн нийгмийн харилцаа үүсдэг.

Эртний хятадын философи сэтгэлгээний Күнзийн сурталтан Зэнз “Хүсэл зориг тогтвол сэтгэл түвшин болно, бодол санаа бат үнэн бол сэтгэл тэгширдэг байна. Сэтгэл тэгшрээгүй бол үзэх сонсох, амтлах, мэдрэхүй сул байна. “Бодол санаандаа бат үнэн” гэдэг нь биеэ хуурахгүй, үзэл бодолдоо тууштай, сэрэмжтэй сайн сургаалыг дагахыг хэлнэ. Гэгээн суртахуйг гийгүүлнэ гэдэг бол эрдэм сурч, бодол санааг бат болгоод, сэтгэл тэгширч бие засарна, биеэ зассанаар гэр түвшин, гэр түвшин бол төр засарна, төр засарваас тэнгэрийн дор түмэн амгалан тогтоно. Өрх гэрийн дотор өршөөлтэй бол улс оронд өршөөл дэлгэрнэ, өршөөлч хүн бусдыг хайрлаж чадна, дээд хүн өршөөл энэрэлийг сахивал доод хүн итгэл журмыг сахина, өршөөл журмыг сахивал үйл хэрэг бүтнэ”^[18] хэмээжээ.

Монголчуудын зан суртахууны төлөвшил, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл: Сэдэвт экспертийн судалгааны тайлан (2010) –д “...ёс зүй нь өөрийн үйлдлийн төлөө, бусад хүмүүс болон нийгэмлэгийн өмнө, өөрийн хүн чанарын өмнө зан суртахууны хариуцлага хүлээх сэтгэлийг хүн бүхэнд төлөвшүүлэх тухай асуудал хамгийн чухал байр суурь эзэлдэг.”^[19] Ёс зүйтэй байх нь өөрийн үнэлэмжийг

¹⁶ Чимид Б., Дашжамц Д. Эрх зүй ёс-суртахуун. УБ., 1987. 103-105 дахь тал

¹⁷ Даш-Ёндон Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж II боть, УБ., 2011. 515 дахь тал

¹⁸ Золзаяа М. Ёс зүй. УБ., 2014. 25 дахь тал

дээшлүүлэхийн зэрэгцээ, бусдын чадвар дадлыг үнэлэхэд тулах цэг болдог. Тулах цэгтэй байхын мөн чанар нь үнэлэмжийн үнэт зүйл юм.

Монгол Улсад ёс журам ба ёс зүйн философийн өөрчлөлт дараах гурван замаар явагдаж байна.

а) Тотилатори дэгдэмийн зүгээс тулган хүлээлгэх замаар хэвшүүлэхийг оролдож байсан коммунист ёс суртахууны хэм хэмжээ, ойлголт, ухагдахууныг шүүмжлэн, нийгэм журамт эрх ашгийг дээдэлсэн философи, үнэт зүйлсээс татгалзах чиг хандлага;

б) Ардчилал, хувь хүний эрхийг дээдлэх зарчим, зах зээлийн харилцаатай холбоотой хувийн эрх ашгийг илүүд үздэг ёс зүйн үнэт зүйлсийг эзэмших, хуулан авч дууриахыг оролдох чиг хандлага;

с) Олон жил хаалттай байсны улмаас мартагдсан үндэсний уламжлалт хэв заншил, ёс журмыг сэргээн хөгжүүлэх оролдлого;^[19]

Иргэний нийгэмд голлох байр суурьтай мэргэжлийн бүлэг, нийгэмлэг, холбоо нь ашиг сонирхлоо нэгтгэн илэрхийлэхдээ тодорхой *мэргэжлийн ёс суртахууны зарчим, хэм хэмжээг дагаж мөрдөх шаардлага* бий болдог..., мөн энэхүү ёс зүйн хүрээнд мэргэжлийн болон ажил хэрэгч ёс суртахуун, байгууллагын ёс зүй, хэрэглээний ба чөлөөт цагийн ёс зүйн асуудлыг холбож үзэх нь чухал^[20] юм. Энэ нь зөвхөн ёс зүй нь сэтгэлгээний уламжлалаас шинэчлэлд биежин хэлбэржиж буй тухай цөөн утгаар дурьдсан нь өгүүлэлийн суурь болж байгаа юм. Ёс зүй бол хүмүүжлийн энгийн үнэт зүйл юм.

Хоёр. Доктор, профессор Б.Чимид: Төрийн мэргэшсэн алба бол “явуулын” улс төрчдийг хуулиар зэвсэглэж, хуульд захирагдаж ажилладаг болгох “оточийн газар” мөн.^[21]

Төр нь хууль тогтоох, хууль биелүүлэх, хууль хамгаалах үндсэн чиг үүргийг^[22] хэрэгжүүлдэг ард түмний төлөөллийн байгууллага бөгөөд төрийн албанд ажиллаж буй этгээдийн ёс зүйн зан үйлээр тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ дүгнэгдэж байдаг.

Аристотель: “Албан тушаал хүнийг илчлэн харуулдаг” гээд, албан тушаал авсан этгээд ойр дотныхон болон нийт нийгэмтэйгээ харьцана. Ийм үеийн ганц шударга ёс нь бусад хүнд ашид тусыг үзүүлсэн сайн сайханд оршино” гэжээ. Ёс суртахуунтай хүн гэдэг бол сайн үйлд нийцсэн оюун ухааныг удирдлага болгодог этгээд^[23] гэж албан тушаалын талаарх философийн ойлголтыг өгсөн нь нийгмийн хөгжлийн ямарч үе шатанд ард түмний нэг хэсэг эрх мэдлийг төр хэрэгжүүлдгийн хувьд ард түмэнгүй төр гэж байхгүйн адил төлөөлөлгүй эрх мэдэл хэрэгжүүлэх төлөөлөлгүй ард түмэн гэж үгүй тул *албатан*^[24] буй албан тушаалтан байх нь ойлгомжтой.

Төрийн албаны тухай хууль (2002)-д Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл

¹⁹ Мөн тэнд. 64 дэх тал.

²⁰ Монголчуудын зан суртахууны төлөвшил, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл. Сэдэвт экспертийн судалгаа. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2010

²¹ Ган-Өлзий Ч. Ёс зүйн философид гарч буй өөрчлөлт. //Б.Даш-Ёндон (ред). Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013. 70 дахь тал

²² Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. Сэдэвт суурь судалгаа. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2014. 92-104 дэх тал

²³ Чимид Б. Төрийг засах ёс. // Ж.Амарсанаа, Ч.Сайнсанаа (ред). УБ., 2014. 43 дахь тал

²⁴ Лүндэндорж Н. Төрийн онол. УБ., 2008. 196-197 дахь тал

ажиллагааг төрийн алба гэнэ. (3.1); төрийн тусгай алба (3.3.3); төрийн тусгай албан тушаал (5.1.3); Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын ангилал, зэрэглэлийг Төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их хурал тогтооно. (7.9); бүх шатны шүүхийн шүүгч (8.1.1); Төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ. (11.1); төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэх (13.1.5); Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл (15)^[25] зааснаар ард түмэнд үйлчлэх, төрд чин үнэнчээр зүтгэх, *хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулах*, ...төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх баталгааг хуулиар бэхжүүлсэн.

Төр анх бий болсноос эхлээд сэтгэгчид төр түүний албан хаагчид нь ямар хүн байвал илүү зохистой талаар олон арван үзэл санаа дэвшүүлсэн. Тухайлбал, Демокрит (МЭӨ 470-365) “Төр бол бүх нийтийн эрх ашиг, сайн сайхан байдал, шударга ёсыг төлөөлдөг учир төрийн эрх ашиг бүхнээс дээр байна. Зохион байгуулалт сайтай ухаалаг удирдагчтай төр бол ард түмний түшиг тулгуур юм.”^[26] Засаглал хуваарилах онолын дагуу төрийн эрх мэдлийг хууль тогтоож, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл гэж хуваасан, эрх мэдлийг хэрэгжүүлэгч нь төрийн албан хаагч болдог.

Төрийн албан хаагчид хуулийн болон захиргааны дүрэм, журмын хүрээнд өөрсдийн үүргээ үр дүнтэй, үр ашигтай болон зарчмын дагуу гүйцэтгэнэ.^[27]

Төрийн албаны ёс зүйн хамгийн түгээмэл категори, ойлголтуудад:

1. Мэргэжлийн үүрэг - тухайн ажил мэргэжлийг гүйцэтгэж байгаа ажилтны ажлын онцлогийг илтгэн харуулдаг. Хүний аливаа үйлдэл, үр дүн хүлээсэн зорилго нь үүрэг биелүүлэхийг шаарддаг. Ёс суртахууны үүрэг нийтлэг, тусгай гэж хоёр түвшинд байна. Нийтлэг үүрэг нь өдөр тутмын байна. Тусгай үүрэг нь мэргэжлийн болон тодорхой нэг нөхцөлийн үед байна.^[28]

2. Мэргэжлийн хариуцлага - албан хаагч өөрийнхөө өмнө, бусдын өмнө, төрийн өмнө хариуцлага хүлээнэ. Хариуцлага нь өөрийн болон бусдын өмнө хүлээсэн сахилга, дэг журам юм. Хувь хүний хариуцлага нь нийгмийн өмнө эрх зүйн хэм хэмжээг мөрдөж, ёс суртахууны үнэт зүйлийг эрхэмлэх ухамсараар тодорхойлогдоно.^[29]

3. Мэргэжлийн нэр хүнд - иргэний болон албаны эрх үүрэг, нийгмийн үнэлэмжээ ухамсарласны үр дүнд мэргэжлийн нэр хүндээ сахин хамгаална. Мэргэжлийн нэр хүндийн нөгөө тал нь мэргэжлийн үүрэг болон ажилтны зан суртахууны шинжээр бас хэмжигдэнэ.^[30] Ёс зүй нь нэр хүндийг эх орон, ард түмнийхээ тусын тулд шургуу хөдөлмөрлөх, гүн гүнзгий мэдлэгтэй байх, ёс суртахууны өндөр соёлтой байх замаар олж авдаг гэж үздэг.^[31]

4. Мэргэжлийн үнэ цэнэ - мэргэжил мэргэжилтэнд нийгмийн зүгээс өгөх

²⁵ Даш-Ёндон Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж II боть, УБ., 2011. 116 дахь тал

²⁶ Албатан гэж алба бүхий хүн, албан хаагч, албан тушаалтан. Б.Баярсайхан. Монгол хэлний тайлбар толь. Мон судар хэвлэлийн газар. УБ., 2011. 31 дэх тал,

²⁷ Төрийн албаны тухай хууль. 2002

²⁸ Лүндээжанцан Д., нар. Эрх зүйн философи. УБ., 1998. 65 дахь тал

²⁹ Төрийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1996 оны 51/59 дугаар тогтоол

³⁰ Золзаяа М. Ёс зүй, УБ., 2014. 174 дэх тал.

³¹ Мөн тэнд. 176 дахь тал.

үнэлгээ, мэргэжилтний өөрийнх нь үнэлэмж зэрэг ордог.

Дээрхийн гэгээн XIV Далай лам: “Өөрийн сөрөг бодол, мэдэрхүйг дарахын тулд тэднийг өдөөж буй үйлдэл болоод тухайн нөхцөл байдлаас тойрч явах нь зүйтэй ажээ”.^[32]

Төрийн алба нь тодорхой эрх мэдлийг хэрэгжүүлдэг субъект^[33] болохын хувьд төрийн нэрийн өмнөөс ард түмэнд үзүүлэх үйлчилгээг нэр хүндтэй, түргэн шуурхай зохион байгуулах үүргийг гүйцэтгэдэг.

Төрийн албан хаагчийн ёс зүй бол иргэн төрийн албан тушаал эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зарчим, хэм хэмжээ, шаардлага юм. Төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байгаа зүйлс нь хэт ерөнхий, тунхаг шинжтэй байдгаас түүнийг практикт хэрэгжүүлэх тал дээр дутагдалтай байдал ажиглагддаг. Мөн ёс зүйн дүрэм нь зөвхөн хариуцлага, сахилгын хэм хэмжээг зохицуулаад зогсохгүй, урамшуулал, шагналын хэм хэмжээг давхар зохицуулдаг байх нь зүйтэй юм.^[34]

Төрийн албан хаагчдын нийгмийн хариуцлага, зохион байгуулалтын арга хэмжээ дээшлэхгүй байгаа нь нийгмийн хүчин зүйл, бусад олон шалтгаан нөхцөлтэй холбоотой болохыг олж тогтоох хэрэгтэй.

Төрийн алба нийт үндэстний эрх ашгийг хамгаалж үйлчилдэг, нийгмийн практикийн онцгой хэлбэр болохын хувьд ёс зүйн хариуцлагаас ангид байх учиргүй. Төрийн удирдлагын зорилт бол хууль болон нийгмийн хөгжлийн хэрэгцээг харгалзан, нийгэм дэх сөргөлдөөнт үйл явцыг удирдах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх явдал мөн.

Хуульч нь зөвхөн хууль сахиулагч төдий бус төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнд Төрийн албаны хуульд заасны дагуу төрийн тусгай алба хаагч, жинхэнэ алба хаагчид хамаардаг тул төрийн албан хаагч юм.^[35] Төрийн албаны тухай хууль (2002)-д төрийн алба мэргэшсэн, тогтвортой байх (4.2.5) заасан төрийн албаны үндсэн зарчмын дагуу нийгмийн амьдралд ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахихын зэрэгцээ албан тушаал, ажил мэргэжлийн онцлогоос хамаараад ёс зүйн өвөрмөц хэм хэмжээг мөрдөх шаардлага үүсдэг. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолын хавсралт (албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. Төрийн албаны тухай хуулийн 10.4)

Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмээр төрийн захиргааны албан хаагч нь хуулиар харьяалуулсан үүргийг гүйцэтгэхдээ үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн зарчим, удирдлага болгох ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс, дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоосон. Монгол хүний зан суртахуунд уламжлалыг сэргээх нэрээр халхавчилсан мухар сүсэг, муу дадал заншил, өмчийн хойноос улайран хөөцөлдсөн шунал, хэрэглээний соёлгүй байдал, зугаа цэнгэлийн мөрөөсөл, урлагийн утга учиргүй марзан үзүүлбэр, гүтгэлэг, цуурхал, архидалт, мансуурал, зэрэг олон сөрөг зүйлс сэргэн илэрч, хүмүүсийн ухамсарт нөлөөлөх болсныг нуух аргагүй.^[36]

Мэргэжлийн зан суртахуун гэдэг бол хүн ёсны ерөнхий зарчмуудыг тухайн

³² Вандангомбо Р. Төрийн албаны ёс зүй. УБ., 2007. 40 дэх тал

³³ Цогт-Очир Д. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ., 1999. 42 дахь тал

³⁴ Дээрхийн гэгээн XIV Далай лам. Шинэ мянганы хүмүүн төрлөхтний ёс зүй. УБ., 2003. 78 дахь тал

³⁵ Дэмбэрэл Д. Ёс зүйт төр.УБ., 2011. 45 дахь тал

³⁶ Бямбаа С. Төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ., 2008. 101 дэх тал

мэргэжлийн үйл ажиллагааны нөхцөлд тохируулан тодосгож хэрэглэнэ гэсэн үг. Мэргэжлийн ёс зүй нь ёс суртахууны ухамсарын шинэ зарчмууд, шинэ ойлголтыг төлөвшүүлдэггүй, харин үндсэн зарчим, ойлголтуудыг хүний амьдрал үйл ажиллагааны өвөрмөц нөхцөлд зохицуулдаг. Мэргэжлийн ёс суртахууны тодорхой илрэлүүдийг судалдаг салбар ухаан нь мэргэжлийн ёс зүй юм. Мэргэжлийн ёс зүй нь мэргэжил, хариуцсан ажилдаа үнэнч байх, ажил үүргээ чанартай гүйцэтгэх, хувийн эрх ашгийг огоорох, мэргэжлийнхээ нэр хүндийг хамгаалах, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа гүнээ ухамсарлах, үүргээ чанд биелүүлэх журмын тогтолцоо.

Мэргэжлийн ёс зүй нь ёс суртахууны ухамсрын шинэ зарчим, шинэ ойлголтыг төлөвшүүлж буй болгохоосоо илүү нэгэнт тодорхой байгаа зарчим, ойлголтуудыг хүмүүсийн амьдрал үйл ажиллагааны өвөрмөц хүрээнүүдэд зохицуулан хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Мэргэжлийн ёс зүйн үндсэн ойлголт нь тухайн салбарт ажиллаж байгаа хүний ажлын онцлогийг илтгэн харуулж байдаг мэргэжлийн үүрэг хэмээх ойлголт болно.^[37] Мэргэжлийн ёс зүйн уг сурвалж буюу суурь ойлголт нь мэргэжлийн үүрэг. Мэргэжлийн үүрэг нь тухайн хүний ажлыг үр дүнтэй болгодог.^[38] Мэргэжлийн үүрэгт – ажил үүргээ бүрэн ухамсарлах, ажил үүрэгтээ хариуцлагатай хандах, мэргэжлийн онцлогтой холбоотой тавигдах шаардлагыг биелүүлэх (Хуульч мэргэжлийн ёс зүй); зохих шугам байх ёстой байр сууриныхаа эзэн нь байх, мэргэжилтэй холбогдох шинжлэх ухаануудыг судлах, бодитой мэдээллийг аль болох богино хугацаанд цуглуулах, судлах, дүн шинжилгээ хийх, ашиглах чадвар, дадал эзэмших гэх мэт.

Мэргэжлийн ёс зүй нь мэргэжлийн ёс суртахууны үндсэн зарчим, хэм хэмжээ, үнэлэмж, мэргэжлийн ёс суртахууны болон нийгмийн хэрэгцээг хангаж, юу зөв, юу бурууг тухайн мэргэжилтэнд ойлгуулах, үүрэг хариуцлагыг ухамсарлуулах, мэргэжлийг эрхэмлэх, тодорхой зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөртөө хяналт тавих, зохицуулах эрхийг мэргэжилд олгох замаар ёс суртахууны болон нийгмийн хэрэгцээг хангадаг.

Мэргэжлийн ёс зүйн зорилго:

1. Мэргэжлийн ёс суртахууны ойлголтууд, мэргэжилтэнд тавигддаг ёс суртахууны шаардлагыг тодорхойлох;

2. Хүн ёсны ерөнхий зарчмуудыг тухайн ажил, мэргэжилд тохируулж, тодотгуулан тодорхойлох, улам бүр боловсронгуй болгох;

3. Ёс суртахууны шаардлагыг мэргэжлийн хүрээнд хэрэгжүүлэх, зарчмыг сахиулан мөрдүүлэх;

4. Мэргэжлийн байгууллагын удирдах болон бусад ажилтан, албан хаагчид мэргэжлийн ёс суртахууны хэм хэмжээг төлөвшүүлэх;

5. Мэргэжилтний зан суртахуунд хяналт тавих зохицуулах;

Мэргэжлийн ёс суртахууны хэм хэмжээ, баримтлах үндсэн зарчмуудыг мэргэжлийн ёс зүй судалдаг. Мэргэжлийн ёс зүй нь аливаа мэргэжлийн үйл ажиллагааны өвөрмөц төрлүүдийг илэрхийлсэн хэм хэмжээ, стандарт, шаардлагуудтай байна. Энэхүү хэм хэмжээг бүрэлдүүлдэг олон хүчин зүйлийг ерөнхийд нь ангилж үзвэл:

1. Бие хүний төлөвшилт, ёс суртахууны ухамсрын төвшин;

³⁷ Сумъяа Б. Ёс зүйн үндэс. УБ., 2001. 173-177 дахь тал

³⁸ Батбаяр Ц. Ёс зүй. УБ., 2007. 132-136 дахь тал

2. Байгууллагын ёс зүйн дүрэм, дотоод журам, тушаал шийдвэр;^[39]

Ажил, мэргэжлийн онцлог шалгуурт нийцсэн ёс зүйн төлөвшил нь хүмүүжих, суралцах, ажиллах бүхий л үйл явцад хамт өсөн хөгждөг.

Ажил мэргэжил бүхэн өвөрмөц онцлогтой ба ёс суртахууны зарчим, хэм хэмжээгээр өөр өөрийн мэргэжлийн хөдөлмөрийн явцад янз бүрээр хэрэгжиж болно. Мэргэжлийн ёс зүй нь ажил мэргэжилтэй холбоотой ёс суртахууны асуудлыг судалдаг салбар. Тухайлбал, хөдөлмөрийн хамт олны болон мэргэжилтний хоорондын харилцаа, ёс суртахууны үнэт зүйл, өвөрмөц зарчим, мэргэжлийн нэр хүнд, төлөвшлийн онцлог зэргийг судалдаг.

Мэргэжлийн нэр хүнд үүрэг хариуцлагаа ухамсарлаагүйгээс мэргэжилтнүүд хуулийн болон ёс суртахууны зөрчил гаргадаг учир мэргэжлийн ёс суртахууны хэм хэмжээг дагах шаардлагатай.

Төрийг төлөөлж хүнтэй харилцдаг, төрийн хуулийг хэрэглэж, хэрэгжүүлж, зөрчих тохиолдолд зохих хариуцлага хүлээлгэдэг, төрийн хуулийн биелэлтийг хянаж байдаг зэрэг мэргэжлийн онцлог нь хуульчийн ёс суртахуун өвөрмөц шинжтэй байхыг нөхцөлдүүлдэг.^[40]

Гурав. Хуульчийн ёс зүй нь эрх зүй, зан суртахууны ухамсарын харилцаа холбоонд үүсч төлөвшдөг.^[41]

Дээрхийн гэгээн XIV Далай лам: Хуульч хүн бол мэргэжлийн мэдлэг боловсролоо шударга үнэний төлөө тэмцэхэд хэрэглэх нь чухал ажгуу^[42] гэсэн нь энэ мэргэжлийн үнэ цэнийг хэрхэн дүгнэж байгааг илтгэжээ.

Албаны болон мэргэжлийн ёс зүй гэж бусдын нэрийн өмнөөс, тэдний эрх ашгийг хангах үйл ажиллагаа явуулахаар эрх (эрх мэдэл) олж авсан этгээд, эрх олгосон бүтцийн сонирхлыг өөрийн болон бусад хөндлөнгийн сонирхлоос дээгүүр тавьж, энэ зан суртлаа албаны (мэргэжлийн) үйл ажиллагаандаа мөрдлөгө болгохыг ойлгоно.^[43] Хуульчийн ёс зүй нь ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулагдахын хамт давхар хуульчлагдах болсон.

Үндсэн хууль болон шүүх, прокурор, өмгөөлөл, цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, нотариатын тухай хуулиудад ардчилал шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрхийг дээдлэх, хууль ёсыг бэхжүүлэх зэрэг нийтлэг зарчим, хэм хэмжээ тусгалаа олсон нь зөвхөн хууль зүйн төдийгүй, ёс суртахууны ач холбогдолтой юм.

Хуульчийн ёс суртахуун нь манай орны хөдөлмөрчдийн оюун санаа, ухамсар, зан суртахууны дэвшилт уламжлал, соёлын ерөнхий өсөлттэй салшгүй уялдаатай төлөвшинө.^[44] Аливаа мэргэжил ёс зүйн өвөрмөц шаардлагыг өөртөө бий болгодог. Өөрөөр хэлбэл, мэргэжил бүхэн өөрийн ёс зүйтэй байна. Хуульч нь мэргэжлийн онцгой төрөл учраас түүнд ёс зүйн онцлог шаардлага тавигддаг. Энэ нь уг мэргэжлийн онцлогоос урган гардаг ба төрийг төлөөлж иргэдтэй харьцдаг, төрийн хуулийг хэрэгжүүлж, зөрчих тохиолдолд зохих шийтгэл хүлээлгэдэг, хуулийн биелэлтийг хянадаг зэрэг мэргэжлийн онцлог байдлууд нь хуульчийн ёс

³⁹ Тунгалаг Д. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2012. 4 дэх тал

⁴⁰ Сэнгэдорж Т. Хуульчийн мэргэжил. 4 дэх хэвлэл. УБ., 2003.105-112 дахь тал

⁴¹ Дуламсүрэн Ш. Хуульч мэргэжлийн ёс зүй. УБ., 2007. 88 дахь тал

⁴² Дээрхийн гэгээн XIV Далай лам. Шинэ мянганы хүмүүн төрлөхтний ёс зүй. УБ., 2003. 144 дэх тал

⁴³ Тэмүүжин Х. Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур, үндэслэл.// Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ., 2004. 8 дахь тал

⁴⁴ Цогт-Очир Д. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ., 1999. 8 дахь тал

зүйн өндөр шаардлагыг нөхцөлдүүлдэг.

Иргэний ёс зүй бүх хүнд, албан хаагчийн ёс зүй тухайн албан тушаалтанд хамаатай байдаг бол хуульчийн ёс зүй зөвхөн хуульч хүнд л хамаарна. Түүнчлэн, ёс зүйн нийтлэг шаардлагуудаас ангид хуульчийн ёс зүй гэж байх учиргүй. Хуульчийн ёс зүйд ёс суртахууны нийтлэг шаардлагууд мэргэжлийн онцлогтой холбоотойгоор өвөрмөц шинжтэй болж улам нарийсдаг. Энэ талаар ОХУ-ын хууль цаазын нэрт онолч доктор, профессор С.С.Алексеев: “Хуульчийн ёс зүй нь хуульчийн үйл ажиллагааны зан суртахууны нийтлэг зарчмуудыг төдийгүй, мөрдөн байцаах, шүүх, өмгөөлөх зэрэг хууль зүйн ажлын төрлүүдтэй холбоотойгоор түүнд тавигдах ёс суртахууны онцлог шаардлагуудыг нэгэн адил хамаардаг” хэмээн тэмдэглэсэн байдаг. Иймд хуульчид ёс суртахууны нийтлэг шаардлагуудын зэрэгцээ мэргэжлийн ёс зүйн өвөрмөц шаардлага давхар тавигддаг. Үүгээрээ хуульч нь ёс зүйн талаар өндөр үүрэг хариуцлага хүлээж байдаг онцлогтой.

Хуульч нь иргэний хувьд нийгмийн харилцаанд оролцож байгаа бол ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахих учиртай. Харин хуульчийн хувьд ажил үүргээ гүйцэтгэж байгаа бол мэргэжлийн ёс зүйг баримтлах ёстой. Иргэний ёс зүйг биелүүлээгүй тохиолдолд хуульч нь олон нийтийн зүгээс зэмлэл хүлээж болох бөгөөд харин мэргэжлийн ёс зүйн шаардлагыг биелүүлээгүй бол хуулийн буюу ажиллаж буй байгууллагынхаа зүгээс хариуцлага хүлээнэ.

Хуульчийн ёс зүйн боловсрол нь эрх зүйн онолын мэдлэг, хууль зүйн практикт тохиолддог асуудлыг шийдвэрлэж ирсэн туршлага, ёс зүйн онол, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зэрэг олон талын мэдлэг мэдээллийн цогц юм. Хуульч хүн толинд харагдаж буй мэт хүмүүсийн нүдэнд ил тод байдаг тул өөрийгөө хянаж, биеэ зөв авч явах шаардлагатай.

Хууль шүүхийн тогтолцоо нь хүмүүсийн эрх ашгийн эсрэг ажиллах эсвэл ажиллаж байгаа мэт ойлгогдвол хууль тогтоомж хүмүүсийн эрх чөлөөг хангах арга хэрэгсэл байхаа болих учир хуульчийн ёс зүйн асуудал, хүний эрх, ардчилал, эрх зүйт ёсыг хамгаалах чухал хэрэглүүр гэж хэлж болно. Хуульчид ямар ч хамаагүй үнээр хуулийг улс төрийн явуургүй зорилгод гуйвуулахаас хамгаалах ёстой ба нийгмийн гишүүдийн өмнө хүлээсэн тэдний зүй ёсны үүрэг. Үүрэг нь хувь хүнээс бусдын өмнө болон өөрийнхөө өмнө хүлээх хариуцлагын ухамсрыг багтаасан ойлголт. Үүргээ ухамсарлах нь хүн өөрийнхөө үйлдэл, үйл ажиллагаандаа ямагт бодолтой ухаалаг хандахад нөлөөлдөг.

Хариуцлагатай байх нь хуульчийн хараат бус байдлын тулгын чулуу бөгөөд хариуцлагаа ухамсарласан хуульч өөрийгөө хамгаалах бүрэн чадвартай байдаг тул хариуцлагын дархлааг өөртөө бий болгохын тулд хичээх ёстой.

Нийгэмч хүмүүжил олгоход төрийн хууль хэрэгтэй. Сайтар хүмүүжүүлье гэвэл сайн хууль чухал⁴⁵ хуульчийн ёс зүйн боловсрол нь эрх зүйн онолын мэдлэг, хууль зүйн практикт тохиолддог асуудлыг шийдвэрлэж ирсэн туршлага, ёс зүйн онол, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зэрэг олон талын мэдлэг мэдээллийн цогц юм.

Хуульч бүр өөрийн эрхэлж байгаа албан тушаал, мэргэшлийн ёс зүйг даган мөрдөхийн зэрэгцээ, ёс зүйн тухай онолын тулгуур ухагдахууныг сайтар судалж, түүнтэй холбогдуулан амьдрал, нийгмийн хөгжлийн явцтай уялдуулан, ёс зүйн талаар шинэлэгээр сэтгэн, мэргэшил тус бүрээрээ анхаарах, эрхэмлэх гол асуудлыг оновчтой тодорхойлж байх нь бидний үйл ажиллагааны зайлшгүй шаардлага мөн.

⁴⁵ Даш-Ёндон Б. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж II боть, УБ., 2011. 117 дахь тал

Хуульч нь нийгмийн өмнө мэргэжлийн үйл ажиллагаагаа хувийн сонирхлоос зааглаж, хүний эрхийг хамгаалан, хангах үүрэг хүлээснийхээ хувьд хариуцлагатай байх, хувь хүнийхээ зан байдлыг хянах үүрэг ноогддог нь ёс зүйн хувьд тавигдах шаардлагаар хангагдана.

Хуульчийн мэргэжлийн ёс зүй нь ерөнхий ойлголт бол мэргэшлийн ёс зүй нь түүнээс урган гардаг тусгай ойлголт юм. Мэргэшлийн ёс зүй нь мэргэжлийн ёс зүйн үндсэн зарчим, хэм хэмжээнээс салбарлан, мэргэшлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэгдэн, түүний онцлогоос хамаарч, улам нарийссан тусгайлсан шинжийг агуулдаг. Мэргэжлийн ёс зүй нь хуульчийн ажилд ерөнхий шинжтэй байдаг бол мэргэшлийн ёс зүй нь тусгайлсан шинжтэй байдаг.^[46]

Тухайлбал, шүүгч нь төрийн тусгай албан хаагч боловч шүүгч мэргэжлийн үндсэн шалгуур үзүүлэлтийн дагуу хуульчийн ёс зүйн хэм хэмжээг нийтлэг стандартын дагуу дагаж мөрднө.

Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал:

1. Ёс зүйн бус асуудал (non-ethical consideration)
2. Ёс зүйн сонголт (dilemma) ^[47]

Ёс зүйн дүрэмд ёс зүйн наад захын дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоож өгсөн байдаг. Өөрөөр хэлбэл, хориглосон, үүрэг болгосон хэм хэмжээг багтаасан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал: Хариуцлагын зарчим - Хувь хүний хариуцлага - Ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх^[48] гэсэн агуулгын ойлголтыг тусгасан.

Хууль зүйн мэргэшил нь хууль зүйн мэргэжлийн хөгжлийн үр дүн юм. Өөрөөр хэлбэл, хууль зүйн мэргэшил нь хууль зүйн мэргэжлийн төрөлжилт, гүнзгийрэлт мөн.^[49] Энэ утгаас үзвэл шүүгч нь шүүхэд ирсэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажлыг эрхлэх, хуулийн мэргэжлийн ажилтан болохынхоо хувьд төрөлжилтөд, төрийн тусгай албан хаагчийн үүрэг хариуцлагыг бүрнээ ухамсарласан, эрх зүйн тодорхой чиглэлээр нарийн мэргэшин ажиллаж буйн хувьд хууль зүйн гүнзгий бат бэх, улам бүр хөгжиж байх мэдлэгийг эзэмшсэн байхыг шаардана.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах ёс суртахууны хэм хэмжээ, зарчим, шаардлага зэргийг хуульчийн ёс зүйн салбар гэж үздэг. Хуульчийн ёс суртахууны нийтлэг зарчмууд нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шударга ёсыг баримтлах, хууль дээдлэх, алагчлахгүй байх, бодитой, ухаалаг хандах, хараат бус байх, шүүх эрх мэдлийн бие даасан байдлыг хүндэтгэх, хамгаалах, мэргэжлийн үүрэгтээ үнэнч байх, мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх^[50] зэрэг болно. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатчийн ёс зүйн дүрмүүдийг тус бүрээр нь боловсруулж мөрддөг. Энэ утгаараа хуульчийн мэргэжлийн ёс зүй нь нийт хуульчийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах ёс суртахууны үндсэн шаардлагууд болно. *Тухайлбал:* хуульчид төр, ард түмний төлөөх үйлсэд шударгаар зүтгэх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тууштай хамгаалах, хүмүүст үнэн сэтгэлээсээ үйлчлэн туслах, аливаа байгууллага, албан тушаалтан эрхээ зөв эдэлж, үүргээ бүрэн

⁴⁶ Батбаяр Ц. Ёс зүй. УБ., 2007. 158-161 дэх тал

⁴⁷ Адъяабазар Д., Бадралт Л. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хуульчийн ёс зүй. Сургалтын гарын авлага. УБ., 2008. 5 дахь тал

⁴⁸ Амарсанаа Ж. (ред) Эрх зүйн соёл: төлөв хандлага. УБ., 2008. 93 дахь тал.

⁴⁹ Болортогос Б. Хуульч мэргэжил, түүний ёс зүй. УБ., 2012. 11 дэх тал

⁵⁰ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. Хууль, дүрмийн эмхэтгэл. Монголын хуульчдын холбоо. 2014

биелүүлэхэд эрх зүйн бүх арга хэрэгслээр үйлчлэх, мэргэшлийн бүхий л туслалцааг үзүүлэх, төр, нийгэм, иргэдэд харш аливаа хууль бус үйлдлийг үл тэвчин, тууштай тэмцэх, хууль ёсыг цэвэр ариун болгох, зөрчих явдлаас сэргийлж, гарах шалтгаан нөхцлийг арилгах, хууль бус үйлдэлтэй шийдэмгий тэмцэх, хуулийг гуйвуулах, үл хүндэтгэх, тойрон гарах, зайлсхийх, үгүйсгэх, хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах, хуульчид сэжигтэн, яллагдагч, шүүгчидтэй хувийн холбоо тогтоож, ашиг хонжоо харах, ямар нэгэн байдлаар ялгаварлах, тэгш биш хандах, нийтэд тарааж мэдээлэх, төр, иргэн, байгууллагын нууцыг задруулах зэрэг зохисгүй байдал гаргахыг цээрлэж, харилцааны өндөр соёлтой байж өөрийгөө жолоодох ёстой.

Хуульчийн мэргэжлийн ёс зүйн ерөнхийгөөс нэгжид шилжсэн хэв шинж нь баримт бичиг талаасаа “Ёс зүйн дүрэм”-ээр хэлбэржих бөгөөд хууль зүйн нарийн мэргэшил бүрт тохируулан гаргасан ёс зүйн дүрмийг нарийвчлан судлах нь чухал.

Энэ хүрээнд нийт хуульч мэргэжлийн албан хаагчид зонхилдог 15 байгууллагын ёс зүйн дүрэм, дүрмийг батласан байгууллага, албан тушаалтан, дүрмийг батлах хууль зүйн үндэслэлийг судлан үзэхэд: ёс зүйн дүрмийг батлаж буй субъектын хувьд харилцан адилгүй байгаа нь дүрэм батлах хууль зүйн үндэслэлээс ажиглагдаж байна.

Хуульчдын гүйцэтгэх үүргийн үндсэн зарчмууд (НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгсдэд хандах асуудлаарх VIII их хурлаар 1990.8.27-1990.9.7 батласан)-Хуульчдын мэргэжлийн байгууллага (Хуульчид нь өөрсдийн ашиг сонирхлыг илэрхийлсэн, тэднийг бэлтгэх, тасралтгүй боловсрол олгоход тус дөхөм үзүүлэх, мэргэжлийн ашиг сонирхлыг нь хамгаалах мэргэжлийн бие даасан холбоо байгуулах, гишүүн нь байх эрхтэй.) Монголын хуульчдын холбоо, Сахилгын шийтгэлийн арга хэмжээ (Хуульчид мэргэжлийн зан үйлийн хуулийг боловсруулах) Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 2012.3.07, Хуульчдад сахилгын шийтгэлийн арга хэмжээ авах асуудал хуульчдын байгуулсан алагчлалгүй сахилгын хороо (Мэргэжлийн хариуцлагын хороо) хуульд заасан хараат бус байгууллага буюу шүүхээр хэлэлцэгдэх бөгөөд шүүхийн бие даасан хяналтын шатаар хянагдах ёстой.

Эх сурвалжийн жагсаалт.

Ном, сурах бичиг

1. Ж.Амарсанаа нар. Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003
2. Ж.Амарсанаа (ред) Эрх зүйн соёл: төлөв хандлага. УБ., 2008
3. Ж.Амарсанаа нар (ред) Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2014
4. Т.Амаржаргал. Ёс суртахууны тухай өгүүлэх нь. УБ., 1991
5. Ц.Батбаяр. Ёс зүй. Гарын авлага. УБ., 2010
6. Б.Болортогос. Хуульч мэргэжил, түүний ёс зүй. УБ., 2012
7. С.Бямбаа. Төрийн тусгай албан хаагчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ., 2008
8. Р.Вандангомбо. Төрийн албаны ёс зүй. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2007
9. Б.Даш-Ёндон. Эртний Грекийн философи сэтгэлгээний эх сурвалж II, III боть, УБ., 2011
10. Б.Даш-Ёндон (ред). Монголын нийгмийн өөрчлөлт. УБ., 2013
11. Ш.Дуламсүрэн. Хуульч мэргэжлийн ёс зүй. УБ., 2007
12. Д.Дэмбэрэл. Ёс зүйт төр. УБ., 2011
13. Дээрхийн гэгээн XIV Далай лам. Шинэ мянганы хүмүүн төрлөхтний ёс зүй. УБ., 2003

14. М.Золзаяа. Ёс зүй. УБ., 2014
15. Н.Лүндэндорж. Төрийн онол. УБ., 2008
16. Моригава Ясүтомо. Хуульчийн ёс зүй. УБ., 2007
17. С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001
18. Д.Солонго. Төрийн эрх зүйн тайлбар толь. УБ., 2003
19. Б.Сумъяа. Ёс зүйн үндэс. УБ., 2001
20. Т.Сэнгэдорж, С.Энхмэнд. Хуульч мэргэжил: Ёс зүйн асуудал. Сурах бичиг. УБ.,

2012

21. Ханс Кельзен. Хэм хэмжээний тухай ерөнхий онол. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2013
22. Д.Тунгалаг. Ёс зүй. УБ., 2002
23. Д.Тунгалаг. Мэргэжлийн ба хэрэглээний ёс зүй. УБ., 2012
24. Д.Цогт-Очир. Хуульчийн ёс зүйн үндсэн асуудал. УБ., 1999
25. Б.Чимид, Д.Дашжамц нар. Эрх зүй ёс-суртахуун. УБ., 1987
26. Б.Чимид. Төрийг засах ёс. // Ж.Амарсанаа, Ч.Сайнсанаа (ред). УБ., 2014.

Эрдэм шинжилгээ, судалгааны өгүүлэл, нийтлэл

1. Г.Дарьхүү, Г.Удвал нар. Монголын нийгмийн ёс суртахууны доройтол: шалтгаан, шийдвэрлэх арга зам. Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл). 24-30 дахь тал. УБ., 2014
2. С.Нарангэрэл. Ёс суртахуун-эрх зүйн судалгааны зарим үр дүн. Монгол Улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн хүндрэл: шалтгаан, шийдвэрлэх арга зам (Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл). УБ., 2014. 21-24 дэх тал.
3. Х.Тэмүүжин. Хуульчийн ёс зүй, түүнийг тодорхойлох шалгуур, үндэслэл. Хуульчийн ёс зүй гарын авлага, УБ., 2004. 6-9 дэх тал
4. Шакли Ф. Рафетто. Ёс зүй- Сонирхлын зөрчил. Зах зээлийн эдийн засгийн эрх зүйн зохицуулалт дахь ашиг сонирхолын солбицол, түүний үр дагавар. Шихихутуг ХЗД. ОУЭШБХ-ын эмхэтгэл. УБ., 2014

Баримт бичиг, хууль тогтоомж, бусад эрх зүйн актын эмхэтгэл, гарын авлага

1. Д.Адъяабазар., Л.Бадралт. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хуульчийн ёс зүй. Сургалтын гарын авлага. УБ., 2008.
2. Хуульчийн ёс зүйн гарын авлага. УБ., 2004
3. Хууль, дүрмийн эмхэтгэл. Монголын хуульчдын холбоо. 2014
4. Хүний эрх: Эрх зүй, ёс суртахууны асуудлууд II дэвтэр. Хенри Ж.Стайнер, Филип Элстон. Орчуулсан И.Очирбал.
5. Төрийн албан хаагчийн ёс зүй (Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл) УБ., 2006

Судалгааны тайлан

1. Монголчуудын зан суртахууны төлөвшил, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйл. Сэдэвт экспертийн судалгаа. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2010
2. Монгол дахь иргэний нийгмийн төлөвшлийн философи, улс төр, эрх зүйн асуудал. Сэдэвт суурь судалгаа. ШУА-ийн ФСЭХ. УБ., 2014
3. Эрх зүйн судалгаа: тойм, үр дүн, асуудал. ХЗҮХ-ийн судалгаа. Хууль дээдлэх ёс. 2013. №1(41). 59-67 дахь тал

Эрх зүйн актууд

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1948.12.10 дугаар 217/A/III/ тогтоол
3. Төрийн албан тушаалтны ёс зүйн олон улсын дүрэм. НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1996 оны 51/59 дугаар тогтоол
4. Хууль хэрэгжүүлэх албан тушаалтны зан үйлийн тухай хууль, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1979 оны 34/169 дугаар тогтоол
5. Төрийн албаны тухай хууль. 2002
6. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль. 2012
7. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм. 2014